

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/46

Арвайхээр


Журам батлах тухай

"Эрүүл мэндийн сайдын 2016 оны "Шинжилгээний сорьц зөөвөрлөх журам батлах тухай" А/93, 2019 оны "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" А/327 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Урвалж, оношлуурыг хүлээн авах, хадгалах, түгээх, тээвэрлэх, зарцуулах" журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн ахлах мэргэжилтэн (С.Дуламсүрэн), Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтэн /Н.Дэжидням/ нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ШИВААННҮРДЭВ
ИЮЕ0007

ЭМГ-ын даргын 2019 оны 11-р сарын 12-ны
өдрийн 11/16 дугаар тушаалын хавсралт



УРВАЛЖ, ОНОШЛУУРЫГ ХҮЛЭЭН АВАХ, ХАДГАЛАХ, ТҮГЭЭХ, ТЭЭВЭРЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь лабораторийн шинжилгээний урвалж, оношлуур, хамгаалах хэрэгслийг хүлээж авах, нөөц бүрдүүлэх, тээвэрлэх, хадгалах, зарцуулах болон тайлагнах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Урвалж, оношлуурыг хүлээн авах, хадгалах, тээвэрлэх, зарцуулах журам нь Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, MNS5530:2014 стандарт, Засгийн газрын 2015 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан "Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр, "Эрүүл мэндийн сайдын 2016 оны "Шинжилгээний сорьц зөөвөрлөх журам батлах тухай" А/93, 2019 оны "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" А/327 дугаар тушаал болон холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.
- 1.3 Урвалж, оношлуурыг эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах, ханган нийлүүлэх гэрээгээр захиалж авна.
- 1.4 Урвалж, оношлуурыг орлогод авч, эргэлтийн хөрөнгөд бүртгэнэ.
- 1.5 Эрүүл мэндийн байгууллагууд нь онцгой нөхцөлд хэрэглэх, тасралтгүй байдлыг хангах үүднээс урвалж, оношлуурын тодорхой нөөцтэй байна.
- 1.6 Энэхүү журмыг эрүүл мэндийн байгууллагууд мөрдөж ажиллана.

Хоёр. Урвалж, оношлуур, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авах

- 2.1 Эм, эмнэлгийн хэрэгслийн тендерээр болон олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдсэн лабораторийн шинжилгээний урвалж, оношлуурыг техникийн тодорхойлолт, мэргэжлийн байгууллагын дүгнэлттэй хүлээн авна.
- 2.2 Урвалж, оношлуурын үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч байгууллагын тодорхойлолт, хадгалалт, тээвэрлэлтийн горим, үйлдвэрлэгчийн монгол хэл дээр бичигдсэн заавар, серийн дугаар, үйлдвэрлэсэн болон дуусах хугацаа, сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдал зэргийг нягтлан үзэж хүлээн авна.

2.3 Урвалж, оношлуурыг хүлээн авахдаа Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага /MNS 5530:2014/ стандартыг мөрдөнө.

Гурав. Урвалж, оношлуур, эмнэлгийн хэрэгслийг хадгалах, түгээх

3.1 Ханган нийлүүлэгч байгууллагаас хүлээн авсан урвалж, оношлуурыг хадгалалтын горимын дагуу тасалгааны болон хөргөгчид заасан хэмд хадгалж, өдөр бүр хөргөгчийн болон тасалгааны хэмийн тэмдэглэл хөтөлнө.

3.2 Хадгалалтын онцгой нөхцөл шаардсан урвалж, оношлуурыг зохих шаардлага хангасан орчин нөхцөлд Эмийн санд тавих, нийтлэг шаардлага /MNS 5260:2014/, Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага /MNS 5530:2014/ стандартын дагуу хадгална.

Дөрөв. Урвалж, оношлуурыг тээвэрлэх, зарцуулах

4.1 Урвалж, оношлуурыг тээвэрлэхдээ Эрүүл мэндийн сайдын 2016 оны “Шинжилгээний сорьц зөөвөрлөх журам батлах тухай” А/93, Эрүүл мэндийн газрын даргын 2017 оны “Шинжилгээний сорьц зөөвөрлөх нэгдсэн журам батлах тухай” А/18 дугаар тушаалыг мөрдлөг болгоно.

4.2 Тээвэрлэлтийн онцгой нөхцөл шаардсан урвалж, оношлуурыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу зохих шаардлага хангасан нөхцөлд тээвэрлэнэ.

4.3 Урвалж оношлуурыг зориулалтаар нь зарцуулж, холбогдох анхан шатны бүртгэл маягтад орлого, зарлагыг хөтөлж, баримтжуулна.

Тав. Урвалж, оношлуурын зарцуулалтад тавих хяналт

2.1 Эрүүл мэндийн газар нь эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах тендерээр болон олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдсэн лабораторийн шинжилгээний урвалж, оношлуурын зарцуулалтад хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

2.2 Эрүүл мэндийн газраас жилд 1-2 удаа Бүсийн оношилгоо, эмчилгээний төв болон сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төв, кабинетын урвалж, оношлуурын хадгалалт, зарцуулалт, хэрэглээнд үнэлгээ хийнэ.

- 3 Эрүүл мэндийн байгууллагууд сар бүр дотоод хяналтаар урвалж, оношлуурын хадгалалт, зарцуулалт, хэрэглээнд үнэлгээ хийж, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Зургаа. Урвалж, оношлуурын тайлагналт

- 6.1 Эрүүл мэндийн байгууллагууд нь урвалж, оношлуурын зарцуулалтын тайлан болон нөөцийн мэдээллийг улирал тутам гаргаж, Эрүүл мэндийн газарт дараагийн улирлын эхний сарын 5-ны дотор ирүүлнэ.
- 6.2 Тухайн жилд хэрэглэсэн урвалж, оношлуурын тайланг нэгтгэн гаргаж, хэрэгцээг тодорхойлон, дараа жилийн санхүүгийн төлөвлөлтөд тусган, нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авч, тасралтгүй байдлыг ханган ажиллана.

----oOo----